



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 4/12

Хэрлэн сум

Чанарын менежментийн тогтолцоо  
нэвтрүүлэх ажлын хүрээнд мөрдөгдөх  
дүрэм, журам, чанарын бодлого, зорилтуудыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, байгууллагын үйл ажиллагааг менежментийн сайн түвшинд хүргэх, сайн засаглалыг бий болгох, байгууллагын ажил үйлчилгээг чанаржуулах зорилгоор чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандарт, чанарын менежментийн тогтолцооны ISO 9001 стандартыг орон нутгийн засаг захиргаанд хэрэглэх арга зүйн заавар ISO 18091:2020 стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд мөрдөгдөх Чанарын удирдлагын хамрах хүрээг нэгдүгээр хавсралтаар, Үйл ажиллагааны хамрах хүрээнд тохирсон үйл явцуудыг хоёрдугаар хавсралтаар, Чанарын бодлогыг гуравдугаар хавсралтаар, Чанарын зорилтуудыг дөрөвдүгээр хавсралтаар, Баримт бичиг боловсруулах бүртгэл, хяналтын журмыг тавдугаар хавсралтаар, Шинэ ажилтны чиглүүлэх хөтөлбөрийг зургаадугаар хавсралтаар, Чадамж /Ур чадвар/-ийг долоодугаар хавсралтаар, Гэрээний журмыг наймдугаар хавсралтаар, Үл тохирол бүртгэх, хянах журмыг есдүгээр хавсралтаар, Дотоод аудит хийх журмыг аравдугаар хавсралтаар, Удирдлагын дүн шинжилгээ хийх журмыг арваннэгдүгээр хавсралтаар, Үл тохирол залруулах арга хэмжээг арванхоёрдугаар хавсралтаар Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авах журмыг арванзургаадугаар хавсралтаар, Эрсдлийн менежментийн журмыг арвандолоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандарт, Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001 стандартыг орон нутгийн засаг захиргаанд хэрэглэх арга зүйн заавар ISO 18091:2020 стандартыг аймгийн Засаг Даргын Тамгын Газрын үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр хамрах хүрээг тогтоосугай.

231030520

2.

3. Дээрхи дүрэм, журам, чанарын бодлого, зорилтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийт албан хаагчдад, хэрэгжилтэд хяналт тавьж, үүрэг чиглэлээр хангаж ажиллахыг хэлтсийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР